


2014 оны эхний улирлын эдийн засгийн өсөлт 7.4%

ДНБ 2014 оны I улиралд оны үнээр 3.4 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 18.3%, харин 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1.15 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 7.4% тус тус өссөн байна. Энэ нь өнгөрсөн жилийн мөн үеэс 0.3 нэгжээр өссөн үзүүлэлт юм. ДНБ ийнхүү өсөхөд ХАА-н салбар 18.4%, Барилгын салбар 15.8%-иар өссөн нь голлон нөлөөлжээ.




Төсвийн алдагдал 105 тэрбум төгрөг

2014 оны эхний 4 сарын байдлаар улсын нэгдсэн төсвийн орлого өссөн дүнгээр 1,675.8, зарлага 1,781.5 тэрбум төгрөг болж төсвийн тэнцэл 105.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад орлого 5.4%, зарлага 22.6% өссөн байна. Зарлагын өсөлтөд бараа үйлчилгээний зардал 16%, цалин, хөлс 13%, зээлийн үйлчилгээний зардал 3 дахин, татаас ба шилжүүлэг 23%-р өссөн нь нөлөөлжээ.



Гадаад худалдааны алдагдал 93.8 сая ам.доллар

Нийт бараа эргэлт 4 дүгээр сарын байдлаар 2,958.6 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.18% өссөн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад экспорт 1,432.4 сая ам.долларт хүрч 18% өссөн бол импорт 1,526.2 сая ам. доллар болж 12.3% буурснаар гадаад худалдааны алдагдал 93.8 сая ам.долларт хүрч өсөв. Харин өмнөх сарынхтай харьцуулбал экспорт 13%, импорт 38% өссөн байна. Мөн нүүрсний экспорт өмнөх оны мөн үеэс 20% буурч 272.6 сая ам.долларт хүрсэн бол зэсийн баяжмалынх 92% өсч 530.2 сая ам.доллар болов.



Төгрөгийн ханш суларсан хэвээр

Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш энэ сард 1,784.1 төгрөгт хүрсэн нь өмнөх сарынхтай харьцуулахад 0.7%, өнгөрсөн оны мөн үеэс 25.9% суларсан үзүүлэлт юм. Гадаад валютын албан нөөц энэ оны 1 дүгээр сарын байдлаар 2 тэрбум 446 сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн сарынхаас 8.8% өсч, өнгөрсөн оны мөн үеэс 40.1% буурсан байна.



Инфляц 12.3%

Улсын хэмжээнд тооцсон инфляцын жилийн түвшин 12.3%-д хүрэв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 1.9 нэгжээр их үзүүлэлт юм. Инфляц оны эхнээс 4.6%, өмнөх сараас 1% өсөхөд хүнсний бараа, ундаа, усны болон хувцас, бөс бараа, гутлын бүлгүүдийн дүнгийн өсөлт нөлөөлөв. Жилийн 12.3% хүрэхэд боловсролын үйлчилгээ, хувцас, бөс бараа, гутал зэрэг бүлгийн өсөлтөөс гадна гэр ахуйн тавилга, барааны бүлгийн хэрэглээний үнэ өссөн нь голлон нөлөө үзүүлэв.




Эх сурвалж: УСХ, МБ

САНХҮҮГИЙН САЛБАР: МӨНГӨ, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ


Мөнгөний нийлүүлэлт (M2) 10.2 их наяд төгрөг

M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 42% нэмэгдэж, өнгөрсөн сарынхаас 2.9% өсч 10.2 их наяд төгрөгт (5.72 тэрбум ам.доллар) хүрэв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 10.8%, өмнөх сарынхаас 5% өсөж 841.6 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 8.2%-ийг эзэлж байна.




Валютын хадгаламж буурав

Нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 53.3%, өмнөх сарынхаас 0.1% өсч 7.2 их наяд төгрөгт (4.03 тэрбум ам.доллар) хүрэв. Нийт хадгаламжийн 5.7 их наяд буюу 80%-ийг төгрөгийн хадгаламж, үлдсэн 1.45 их наяд буюу 20%-ийг валютынх эзэлж байна. Төгрөгийн хадгаламж өмнөх сарынхтай харьцуулахад 10.7% өссөн бол валютынх 27.3% буурчээ.



Чанаргүй зээлийн хэмжээ өсөв

Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх сарынхаас 3.1%, харин өнгөрсөн оны мөн үеэс 51.2% нэмэгдэж, 11.7 их наяд төгрөг (6.58 тэрбум ам.доллар) боллоо. Чанаргүй зээлийн хэмжээ өнгөрсөн оныхоос 98.5%, өмнөх сараас 3.6% өсч 616 тэрбум төгрөгт буюу нийт зээлийн 5.25% эзэлж өнгөрсөн сарынхаас 0.05 нэгжээр өсөв. Банкуудын төгрөгийн зээлийн хүү (жилийн, жигнэсэн дундаж) өмнөх жилийнхээс 0.3 нэгжээр өсч 19.4%, валютынх өнгөрсөн оны мөн үеэс 1.1 нэгжээр буурч 12.1% болов.



Эх сурвалж: УСХ, МБ

Сарын онцлох үйл явдал

- > Монгол Улсын ерөнхий сайд Н. Алтанхуяг "Рио-Тинто" группын гүйцэтгэх захирал Уолшд "Оюутолгой" төслийн далд уурхайн санхүүжилтыг эрчимжүүлэх талаар захидал илгээв.
- > "Монголын хөрөнгө оруулалтын чуулган" 3 дахь жилдээ Лондон хотноо зохион байгуулагдав.
- > Төрийн орон сууцны корпорацийн захиалгаар баригдаж буй "Буянт-Ухаа-1" 1764 айлын орон сууцны эхний ээлжийн 567 айлын орон сууцны захиалга үргэлжилж байна. Орон сууцанд орохыг хүссэн иргэд их байгаа тул ирэх сард орон сууцанд орох иргэдийг сугалаагаар тодруулахаар болов.

Хураангуй

Эдийн засгийн өсөлт эхний улирлын байдлаар өндөр өсөлттэй жилийг гүйцээгүй хэдий ч (2012 оны эхний улиралд ДНБ 15.9% өссөн) өмнөх оны түвшнээс 0.3 нэгжээр өссөн буюу 7.4 хувь байлаа. Эдийн засагт валютын ханшийн огцом сулрал, инфляцийн өндөр түвшин зэрэг сөрөг нөхцлүүд байсан ч хөдөө аж ахуй, аж үйлдвэр, барилгын салбарт өсөлт бий болсон нь эдийн засаг эрчимтэй хэвээр байхад нөлөөлжээ. Олон улсын байгууллагууд болон Засгийн газрын тооцоолж буйгаар эдийн засгийн өсөлт 2014 онд 9.5%-12.9% буюу хоёр оронтой тоонд хэвээр байх магадлал өндөр байна. Түүнчлэн Дэлхийн банк манай улсын 2014 оны эдийн засгийн өсөлтийг өнгөрсөн 10 сард таамаглаж байснаас өсгөн 10.3%-иас 11.4% болгон таамаглалаа дээшлүүлсэн байна. Тэдний үзэж байгаагаар 2013 оны эдийн засгийн өсөлт, эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлогуудыг амжилттай хэрэгжүүлсэн, он гарсаар хэрэгжиж эхэлсэн хуулиуд зэрэг нь үүнд нөлөөлжээ. Гэхдээ энэ таамаглал бодит болохын тулд одоо үүсээд буй эдийн засгийн сөрөг нөхцөл байдлыг арилгах, тодорхой бодлого хэрэгжүүлэх, гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх шаардлагатай. Уул уурхайн салбарын хувьд экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрсний экспорт буурсан хэвээр байна. 4-р сарын байдлаар нүүрсний экспорт биет хэмжээгээр өмнөх оны мөн үеэс 7.1% өсөлттэй байгаа ч үнийн дүнгээр 19.5% буураад байна. Харин зэсийн экспортын орлого өмнөх оноос хоёр дахин өсөөд буй нь экспортын орлого нийт дүнгээр нэмэгдэхэд нөлөөлжээ. 2012 оны байдлаар нүүрсний экспортын дүнгээс 2.3 дахин бага байсан зэсийн экспорт он гарсаар нүүрсний орлогыг давж гадаад худалдаанд нүүрснээс бараг хоёр дахин илүү орлого оруулах болсон юм. Экспортын орлого нэмэгдэхийн зэрэгцээ импортын орлого өмнөх оноос 12.3% буурснаас гадаад худалдааны алдагдал буурч тэнцвэржиж ирлээ.



САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ 2014 оны IV сар

Энэ нь худалдан авах чадвар буурч буй сөрөг дохио хэдий ч нөгөө талаас богино хугацаандаа төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулахаар байна. Валютын ханшийн үргэлжилсэн сулралт, инфляцийн хоёр оронтой түвшин зэрэг нь эдийн засгийн өсөлтийг үл хамааран иргэдийн бодит амьдрал болоод хувийн секторын үйл ажиллагаанд ихээхэн хүндрэл учруулж байна. Эдийн засагт үүссэн энэхүү сөрөг нөхцөл байдал нь юун түрүүн гадаад валютын дотогшлох урсгал буурсантай холбоотой бөгөөд Монголбанкны зүгээс энэ нь хараахан эдийн засгийн хямрал биш харин төлбөрийн тэнцлийн хямрал юм хэмээн тайлбарлаж байна. Түүнчлэн 2014 оны 1-р улиралд нийт 292.8 сая ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орсон нь өмнөх оны мөн үеэс 2.9 дахин буурсан (843.9 сая ам.дол) үзүүлэлт юм. 4, 5-р сард S&P, Moody's аль аль нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийг буурууллаа. Гадаадын хөрөнгө оруулалт буурсан, валютын урсгал багассан зэрэг нь эдийн засагт дарамт үзүүлж буй, нөгөөтэйгүүр гадаад өрийн хэмжээ нэмэгдэж, гадаад валютын албан нөөц буурч байгаа нь гадаад төлбөр тооцоо түргэн гүйцэтгэх чадварыг сулруулж байна гэж үзсэн байна. Засгийн газраас энэхүү үүсээд буй нөхцөл байдлыг сайжруулахын тулд төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх шийдвэр гаргаснаас гадна “Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоног” зарласан бөгөөд гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих, уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж экспортын орлогыг өсгөх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг олон ажлуудыг хийхээр төлөвлөөд байна. Үүний үр дүнд нь экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэн гадаад валютын урсгал сайжирснаар гадаад цэвэр актив өсч, санхүүгийн болон макро тогтвортой байдлаа хангахын сацуу эдийн засгийн тэнцвэртэй өсөлтөө хадгалах нөхцөл бүрдэнэ хэмээн үзэж байна.